Аудитыг 2022 оны 3 дугаар сарын 17-аас 2022 оны 3 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Булган аймаг дахь аудитын газрын аудитор Төрийн аудитын газрын Тэргүүлэх аудитор Д.Анхбаяр хоёр дахь шатны, аудитын менежер Ж.Энхцоодол, нар анхан шатны хяналтыг тус тус хэрэгжүүлэн, ахлах аудитор Г.Намчинүрэн хариуцаж гүйцэтгэв.

2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 04-ны өдрийн 01/63 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Орхон сумын засаг даргын үйл ажиллагааны эрхэм зорилго нь Сумынхаа онцлог давуу тал нөөц боломжинд түшиглэн нийгэм эдийн засгийн хөгжлийн бие даасан байдлыг хангаж иргэдийн эрүүл аюулгүй орчинд сурч хөгжих ая тухтай амар тайван ажиллаж амьдрах амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг урьдчилан төлөвлөж орон нутгийн тогтвортой тэнцвэрт хөгжлийг хангахад оршино гэж тодорхойлжээ.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Засгийн газрын бодлого шийдвэрийг сурталчлах, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах;

- Төрийн хууль тогтоомжийг сурталчлах хэрэгжүүлэх;
- Сумын хүн ам, ХХАА-н үйлдвэрлэл, үйлчилгээний бүртгэл судалгааг хөтөлж, дээд шатны байгууллагыг мэдээ мэдээллээр хангах;
- Сумын хөгжлийн хөтөлбөр, Засаг даргын Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа Төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэж, төрийн албаны стандартыг хангахад гол анхаарлаа чиглүүлэн ажиллах

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Орхон сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тайлант онд Санхүүгийн хяналт, аудитын албанаас харьяа төсвийн шууд захирагчдын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, ажил гүйлгээг аккрузаль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардал 3,144.5 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 35.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл сая, эцсийн үлдэгдэл 449.2 сая төгрөг болж, 321.5 сая төгрөгөөр буюу 251.7 хувиар өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл				/сая төгрөг/	
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь	
Касст байгаа бэлэн мөнгө					
Төрийн сангийн харилцах	127.7	449.2	321.5	100.0	

Замд яваа мөнгөн хөрөнгө				
Хадгаламж				
Дүн	127.7	449.2	321.5	100.0
Үүнээс байгууллагаар	-	-	-	-
Орон нутгийн ерөнхий орлого	50.4	181.8	131.4	40.5
Орон нутаг хөгжлийн сан	55.1	114.8	59.7	25.6
Сум хөгжлийн сан	2.6	93.3	90.7	20.8
Байгаль хамгаалах сан	19.2	20.0	0.8	4.5
Жижиг дундын үйлдвэр дэмжих сан	0.4	16.4	16	3.7
Эрүүл мэндийн төв		22.9	22.9	5.1
Дүн	127.7	449.2	321.5	100
Эх сурвалж: Орхон сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан				

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 449.2 сая төгрөгөөс 181.8 сая төгрөг нь төрийн сангийн ерөнхий орлогын харилцах дансанд, 244.5 сая төгрөг бусад төсөл нөөцийн харилцах дансанд, 22.9 сая төгрөг нь Эрүүл мэндийн төвийн нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд тус тус байршиж байна.

Аудитын илрүүлэлт:

- ИТХ-аар зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэлгүй хийгдээгүй 7 төсөл, хөтөлбөр арга хэмжээнд 207.2 сая төгрөгийг төлөвлөж батлуулсан нь Төсвийн тухай хуулийн 29.4 дүгээр заалтыг зөрчсөн. Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтын 43.2-43.4-д заасныг зөрчсөн байна.

3.5.3 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 399.6 сая төгрөг болж 14.5 сая төгрөгөөр буюу 3.8 хувиар өссөн байна.

Хүснэгт № 2 Авлагын үлдэгдэл				/сая төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	
Ажиллагчидтай холбогдсон авлага	2.9	0.5	-2.4	
Төлбөртэй үйлчилгээний авлага			0	
Татаас, санхүүжилтийн авлага		126.6	126.6	
Зээлийн хүүгийн авлага			0	
Бусад авлага	6	2.1	-3.9	
Зээлийн авлага	376.2	270.4	-105.8	
Дүн	385.1	399.6	14.5	
Үүнээс байгууллагаар				
Сум хөгжүүлэх сан	361.7	183.4	-178.3	
Байгал хамгаалах сан	1.5	1.8	0.3	
ЖДҮДС	2.3	74.6	72.3	
Улсын төсвийн хөрөнгө оруулалт	12.2	12.2	0	
Сургууль	0.02	0	-0.02	
Цэцэрлэг	7.4	0	-7.4	
ИТХ	0.04		-0.04	
соел		0.3	0.3	
ЭМТ		127.3	127.3	
Дүн	385.1	399.6	14.5	
Эх сурвалж: Орхон сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан				

Авлагын дансны үлдэгдэлд олон жилийн насжилттай 87.6 сая төгрөгийн авлага байна. Үүнд:

- Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн 87.6 сая төгрөгийн авлага байна.

Аудитын илрүүлэлт:

- Тайлант хугацаанд тооцооллыг тухай бүр хийгээгүйгээс 0.4 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй. /Эрүүл мэндийн төв/
- Зээл олгосон иргэдтэй тооцоо нийлж баталгаажуулаагүй, иргэдээс үйл ажиллагааны тайланг аваагүй, хяналт сул байгаа нь НББ-ийн тухай хуулийн 20.2.5, 20.2.6, Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 5.3.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, Булган аймгийн Засаг даргын 2020 оны 09 сарын 29-ний өдрийн А/424 дүгээр захирамжаар баталсан НБББББ-ийн 4 дүгээр бүлгийн 4.5 дах хэсэгт "Сум хөгжүүлэх сангийн нягтлан бодох бүртгэл" заасан бүртгэлийг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй /Сум хөгжүүлэх сан 183.7 сая төгрөг /

3.5.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эцсийн үлдэгдэл 225.0 сая төгрөг болж 15.9 сая төгрөгөөр буюу 7.6 хувиар өссөн байна.

<i>Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл</i>		<i>/сая төгрөг/</i>	
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	17.2	19.7	2.5
Эм боох материал	20.1	61.4	41.3
Бичиг хэргийн материал	1.9	0.9	-1
Аж ахуйн материал	8.8	1.7	-7.1
Сэлбэг хэрэгсэл	3.5	0	-3.5
Түлш, шатах тослох материал	5.8	3.4	-2.4
Барилгын засварын материал	6.6	0.4	-6.2
Хүнсний материал	4.6	7.8	3.2
Бусад хангамжийн материал	139	129.7	-9.3
Мал амьтад			0
Бэлэн бүтээгднхүүн	1.6	0	-1.6
Дүн	209.1	225	15.9
Үүнээс байгууллагаар			
Байгаль хамгаалах сан	14.2	22	7.8
Соелын төв	7.4	0	-7.4
ЗДТГ	43.2	12.6	-30.6
Сургууль	68.2	61	-7.2
Цэцэрлэг	22.3	28.6	6.3
ИТХ	1.1	0	-1.1
Хүн эмнэлэг	52.7	100.8	48.1
Дүн	209.1	225	15.9
<i>Эх сурвалж: Орхон сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан</i>			

Тайлант онд бараа материал төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 301.0 сая төгрөг, балансаас шилжүүлэн авсан 198.2 сая төгрөг, үнэ төлбөргүй хандиваар авсан 12.0, бусад 0.09 сая төгрөгөөр нэмэгдсэн, худалалдан зарцуулсан 488.5 сая төгрөг, шижүүлэн авсан 1.5 сая төгрөг, акталсан болон бусад 5.4 сая төгрөгөөр хасагдсан байна.

Бараа материалын үлдэгдэлд тайлант оны эцэст эмнэлэг 46.0 сая төгрөгийн эм боох материал, бичиг хэрэг, хамгаалах хувцас хэрэглэл, түлш, хоол хүнсний бараа материалыг Ковид-19 цар тахлын хэрэглээнд гурван сарын нөөц бүрдүүлэх шалтгаанаар, байгаль хамгаалах санд 5.5 сая төгрөгний өвс тэжээлийг нөөц бүрдүүлэх шалтгаанаар нөөцөлсөн.

Аудитын илрүүлэлт:

- ЭМГ-аас ирсэн бараа материалыг орлогод авахдаа тухай бүр орлого авдаггүй, ЭМГ-тай тооцоо нийлээгүй. /ЭМТ 7.0 сая төгрөг/
- Эрүүл мэндийн төвийн даргын А/25 тоот тушаалаар 3 хүний бүрэлдэхүүнтэй комисс томилогдон тооллогыг хэдийд хийж дууссан илгэх хуудас байхгүй бөгөөд тооллого хийгдсэнээс хойш бараа материалын хувьд 30,692,704.5 төгрөгийн зарцуулалт хөдөлгөөн хийгдсэн ч тооллогын дүн 12 дугаар сарын 31-ний үлдэгдлээр тоологдсон, 74.0 сая төгрөгийн бараа материалын баримтын бүрдэл дутуу нь тооллогыг үнэн зөв, бодиттой хийгээгүй нь оршин байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. /ЭМТ/

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 2,484.4 сая төгрөг болж 957.2 сая төгрөгөөр буюу 27.8 хувиар буурсан байна.

<i>Хүснэгт № 04 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл</i>			<i>/сая төгрөг/</i>
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	2,303.4	1,667.0	-636.4
Авто-тээврийн хэрэгсэл	257.0	77.3	-179.7
Машин тоног төхөөрөмж(компьютер)	275.8	220.5	-55.3
Тавилга, аж ахуйн эд хогшил	153.5	102.2	-51.3
Түүх соелын дурсгалт зүйл	1.9	1.9	0.0
Бусад үндсэн хөрөнгө	121.2	89.3	-31.9
Дуусаагүй барилга, байгууламж	174.5	174.5	0.0
Ном	27.8	29.3	1.5
Програм хангамж	6.8	2.7	-4.1
Бусад биет бус хөрөнгө	119.7	119.7	0.0
Дүн	3,441.6	2,484.4	-957.2
Үүнээс байгууллагаар			
Соелын төв	165.7	135.0	-30.7
ЗДТГ	2,057.1	1,588.9	-468.2
Сургууль	620.3	248.2	-372.1
ЭМТ	202.7	184.2	-18.5
ИТХ	8.0	18.0	10.0
Цэцэрлэг	387.8	310.1	-77.7
Дүн	3,441.6	2,484.4	-957.2
<i>Эх сурвалж: Орхон сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан</i>			

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 50.9 сая, балансаас балансад шилжүүлэн авсан 54.2 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 52.6 сая төгрөгөөр нэмэгдсэн, акталсан 13.9 сая төгрөгөөр хасагдсан байна.

Дуусаагүй барилга дансанд баригдаж дуусаагүй ашиглагдаагүй 174.5 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- *Үндсэн хөрөнгийн барилга байгууламж дансанд бүртгэлтэй 5.9 сая төгрөгийн вакум цонх, авто тээврийн хэрэгсэл дансанд бүртгэлтэй 2.4 сая төгрөгийн доторлогоо, машин тоног төхөөрөмжинд бүртгэлтэй төхөөрөмжинд бүртгэлтэй 0.4 сая төгрөгийн сандал бүртгэлтэй байгаа нь НББОУС, Сангийн сайдын 388 дугаар журмыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. /Эрүүл мэндийн төв/*

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эцсийн үлдэгдэл 0.84 сая төгрөг болж 1.0 сая төгрөгөөр буюу 54.8 хувиар буурсан байна.

<i>Хүснэгт №05 Нийт өр төлбөрийн үлдэгдэл</i>				<i>/сая төгрөг/</i>	
Үзүүлэлт	Эхний	Эцсийн	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь	
	үлдэгдэл	үлдэгдэл			
Ажилагсадтай холбоотой өглөг	1.82	0.09	-1.7	10.7	
Байгууллагад төлөх өглөг	0.03	0.75	0.7	89.3	
Хувь хүмүүст өгөх өглөг	0.01	0	0.0		
Нийт дүн	1.86	0.84	-1.0	100.0	
Үүнээс байгууллагаар					
ЗДТГ	0.01	0.75	0.7	89.3	
СӨБ	0.03	0.00	0.0	0.0	
ЕБС	1.82	0.00	-1.8	0.0	
ЭМТ		0.09	0.1	10.7	
Нийт дүн	1.86	0.84	-1.0	100.0	

Эх сурвалж: Орхон сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 0.84 сая төгрөгийн өр байна. Үүнд:

- ЗДТГ 0.75 сая төгрөгийн дулааны болон, НДШ-д төлөх өглөг;
- ЭМТ 0.09 сая төгрөгийн НДШ-т төлөх өглөг байна.

Аудитын илрүүлэлт:

- *Өмнөх оны халаалтын зардал 3.2 сая төгрөгийн дутуу үлдэгдлийг санхүүгийн тайланд дутуу илэрхийлсэн. /Засаг даргын тамгын газар/*

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 3,557.5 сая төгрөг болж 291.8 сая төгрөгөөр буюу 8.9 хувиар өссөн байна.

Хүснэгт № 31. Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	864.3	864.3	0	24.30
Хуримтлагдсан үр дүн	1192.3	1484.1	291.8	41.72
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1209.1	1209.1	0	33.99
Дүн	3,265.7	3,557.5	291.8	100.00

Эх сурвалж: Засгийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 3,557.5 сая төгрөг болж 291.8 сая төгрөгөөр буюу 8.9 хувиар өссөн нь үндсэн хөрөнгийн худалдан авсан, өвс тэжээлийн нөөц, бараа материалын нөөц үүсгэсэн нь шалтгаалжээ.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл тайлант онд өөрчлөлт ороогүй байна.

Хуримтлагдсан үр дүн 1,484.1 сая төгрөг болж 291.8 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны үр дүн ашигтай тайлагнасан нь шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн Бодлогын өөрчлөлтөөр 72.3 сая төгрөгийн залруулга хийгдсэн нь сум хөгжүүлэх сангаас ЖДҮДС-ийн хөрөнгийг салгаж бүртгэсэнтэй холбоотой байна.

3.5.10 Орлогын данс

Орлогын төлөвлөгөөг 274.1 сая төгрөгөөр баталж, 327.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 119.63 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт № .. Төвлөрүүлэх орлого /сая.төгрөг/

	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Орлогын төрөл				
УРСГАЛ ОРЛОГО	274.10	327.90	53.80	119.63
ТАТВАРЫН ОРЛОГО	251.10	287.40	36.30	114.46
Орлогын албан татвар	55.50	70.80	15.30	127.57
Үйл ажиллагааны орлого	11.50	47.10	35.60	409.57
Хадгаламжийн хүүгийн орлого	16.00	18.10	2.10	113.13
Суутгагчийн орлогын албан татвар	18.00	5.60	(12.40)	31.11
Өмчийн татвар	134.00	132.80	(1.20)	99.10
Бууны татвар	3.00	3.20	0.20	106.67
Малд ноогдуулах албан татвар	131.00	129.60	(1.40)	98.93
Бусад татвар	61.60	83.80	22.20	136.04
Улсын тэмдэгтийн хураамж	5.00	6.90	1.90	138.00
Газрын төлбөр	11.30	6.00	(5.30)	53.10
Ойгоос хэрэглээний мод түлээ	26.70	44.10	-	165.17
ашигласны төлбөр				
Ан амьтан агнах		0.30		
Ус ашигласны төлбөр	0.90	8.00	7.10	888.89
ТүгээмэлТархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	12.00	13.40	1.40	111.67
Хог хаягдал	5.70	5.10	(0.60)	89.47
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	23.00	40.50	17.50	176.09
Хүү торгуулийн орлого	16.00	35.80	19.80	223.75
Нэр заагдаагүй бусад орлого	6.00	4.00	(2.00)	66.67
Түрээсийн орлого			-	
Төсөвт газрын өөрийн орлого	1.00	0.70	(0.30)	70.00
Нийт дүн	274.10	327.90	53.80	182.95

Орлогын гүйцэтгэлийг нэр төрлөөр нь авч үзвэл үйл ажиллагааны орлого 409.6 хувь, хадгаламжийн хүүгийн орлого 113.1 хувь, хүү торгуулийн орлого 223 хувь, бусад татвар

136.0, улсын тэмтэгийн хураамж 138.0, ус ашигласны төлбөр 888.8, бууны албан татвар 106.6, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 111.6 хувиар тус тус давуулан биелүүлсэн байна.

Суутгагчийн орлогын албан татвар 31.1, бууны татвар 33.3, газрын төлбөр 53.1, хог хаягдал 89.5, нэр заагдаагүй бусад орлого 66.6 хувиар тус тус тасарсан байна.

Орлого даван биелсэн нь ХХОАТХ-ийн 23 дугаар зүйлд өөрчлөлт орсон, иргэдийн хадгаламж өссөн, өмнөх оны татварын өр барагдсан, төлөвлөгдөөгүй дуудлага худалдаа явагдаж орлого төвлөрсөн, иргэдийн түлээний аймгийн ИТХ-аас ойгоос хэрэглэх ойн нөөцийн хэмжээ буурсан, ЗГ-аас усны төлбөрийг чөлөөлсөн, хяналт шалгалтаар торгуулийн арга хэмжээ өмнөх оноос нэмэгдсэн нь нөлөөлсөн бол орлого тасарсан нь ХХОАТХ-ийн 23 дугаар зүйлд өөрчлөлт орсон, газрын даамал Covid-19 цар тахалтай холбоотойгоор газрын төлбөрийг барагдуулаагүй, ЗГ-аас хог хаягдлын төлбөрийг чөлөөлсөнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- *Тайлант онд малын хөлийн татвар нийт 28.8 сая, газрын төлбөрийн орлого 5.4 сая төгрөгийг төсөвт дутуу төвлөрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 41.2.1-д "хуулийн дагуу улс орон нутгийн төсөвт оруулах болон тухайн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасныг зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй.*

3.5.11 Зардлын данс

Зардлын дансадтай холбоотой 45.2 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

- *Цалингийн урьдчилгааг болон өглөгийг авлага, орлогын дансанд журналын бичилтийг алдаатай тайлагнасан нь НБББББ-ын 5.2, 5.9, 5.10, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. /Эрүүл мэндийн төв 40.4 сая төгрөг/*
- *Засаг даргын нөөц хөрөнгийг журамд нийцүүлэн зарцуулаагүй, кино зараг авалтын хоолны зардалд 1.0 сая төгрөгийг зарцуулж Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 1.1 дэх заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн ба зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна./Засаг даргын тамгын газар/*
- *Үндсэн жолоочид давхар хөдөө аж ахуйн тасгийн жолоочийн ажлыг хавсран гүйцэтгэсний нэмэгдэл цалин 0.9 сая төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д "Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" гэсэн заалтыг зөрчсөн мөн санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.*
- *Өмнөх онд бүлэг хооронд зардлыг шилжүүлэн зарцуулахгүй байх гэсэн зөвлөмж хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй буюу цалингийн зардлаас НДШ-ийн зардалд 2.2, түлш халаалтын зардлаас 2 хүнд нэг удаагийн тэтгэмж буюу түлээний хөнгөлөлт 0.1, түлш халаалтын зардлаас айл, төгрөг аж ахуй нэгжид ус түгээгчийн ажлын хөлс 0.6, нийт 2.9 сая төгрөгийг зарцуулсан нь Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журмын 5.5 дахь заалт, сангийн сайдын 2015 оны 01 дүгээр 20-ны өдрийн 7-р тушаалыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна. /Засаг даргын тамгын газар/*

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Улсын /орон нутгийн / төсвийн орлого бүрдүүлэлт

Орхон сумын ИТХ-ын 2021 оны орон нутгийн төсөв батлах тухай 3/01 дугаар тогтоолд зааснаар Н.Амартүвшин тайлант онд 161.5 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 150.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 93.2 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт № Үйл ажиллагааны орлого	/сая.төгрөг/			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Байгууллагын нэр				
Сургууль		0.0	0.0	
Цэцэрлэг			0.0	
ЗДТГ	1.0	0.7	-0.3	70.0
МСТөв	0.5	0.1	-0.5	10.0
сум хөгжүүлэх сан	120.0	107.5	-12.5	89.6
байгал хамгаалах сан	40.0	26.2	-13.8	65.5
Жижиг дунд	0.0	16.0	16.0	
дүн	161.5	150.5	-11.1	93.2

Сум хөгжүүлэх сангийн орлого 12.4, Байгаль хамгаалах сан 13.8, Засаг даргын тамгын газрын орлого 0.3, Соёлын төв орлого 0.4 сая төгрөгөөр тус тус тасарсан нь цар тахалтай холбоотойгоор тухайн байгууллагын өөрийн орлоготой үйл ажиллагаа явуулаагүй нь шалтгаалсан байна .

Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2518.2 сая төгрөгөөр, нийт зарлагыг 2518.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 165.1 сая төгрөгөөр бууруулж 2353.1 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь тайлант онд төсвийн хэмнэлттэй холбоотойгоор зардлыг бууруулж баталсан байна.

Хүснэгт№ 7 Төсвийн төлөвлөлт байгуулагаар	/сая.төгрөг/		
Байгууллагын нэр	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Зөрүү
ИТХурал	85.4	75.8	9.6
ЗДТГ	528	492.2	35.8
МСТөв	110.4	78.2	32.2
СЭМТ	468.2	441.0	27.2
Сургууль	669.8	557.1	112.7
Цэцэрлэг	240.4	210.6	29.8
сум хөгжүүлэх сан	120.0	120.0	0
байгал хамгаалах сан	40.0	40.0	0
орон нутгийн хөгжлийн сан	256.0	338.2	-82.2
дүн	2518.2	2353.1	165.1

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 32 хөтөлбөрт зориулан 2,353.1 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,856.2 сая төгрөгийг урсгал зардалд, 376.8 сая төгрөгийг урсгал шилжүүлгийн зардалд, 120.0 сая төгрөгийг эргэн төлөгдөх зээлд зарцуулахаар баталжээ.

Нийт зардлын 1,038.0 сая төгрөгийг улсын төсвөөс, 1,042.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 24.6 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 101.4 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 161.5 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Хүснэгт№ Төсвийн гүйцэтгэл байгууллагаар					/сая. төгрөг/	
Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	Улсын төсөвт төвлөрүүлсэн	Орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн
Сургууль	557.3	533.0	-24.3	95.6	21.8	0
Цэцэрлэг	210.6	189.6	-21.0	90.0	20.6	0
СЭМТ	440.8	405.3	-35.5	91.9		
ИТХ	75.8	74.6	-1.2	98.4		0.9
ЗДТГ	492.2	488.4	-3.8	99.2		2.7
Стөв	78.2	72.9	-5.3	93.2		4.8
сум хөгжүүлэх сан	120.0	16.8	-103.2	14.0		
байгал хамгаалах сан	40.0	25.3	-14.7	63.3		
орон нутгийн хөгжлийн сан	338.2	119.7	-218.5	35.4		
дүн	2353.1	1925.6	-427.5	81.8	42.4	8.4

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 966.0 сая төгрөгийг, орон нутгийн төсвөөс 785.9 сая төгрөгийг, орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих 171.2, Эрүүл мэндийн даатгалын сангаас 6.9 сая төгрөгийг, үндсэн үйл ажиллагааны орлогос 134.5 нийт 2,094.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Эрүүл мэндийн даатгалаас олгох санхүүжилт 17.6 сая төгрөгөөр дутуу олгогдсон байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 150.5 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 11.0 сая төгрөгөөр дутсан нь Засаг даргын тамгын газрын орлого 0.3, байгаль хамгаалах сангийн орлого 13.8, сум хөгжүүлэх сангийн орлого 12.5 сая төгрөгөөр тасарсан зэргээс шалтгаалжээ.

Хүснэгт№ Төсвийн гүйцэтгэл хөтөлбөрөөр /сая төгрөг/					
Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	
71801/80109		30.5	30.2	0.3	99.0
71801/81807		15.9	4.2	11.7	26.4
71801/81834		57.4	52.5	4.9	91.5
71801/81835		106.3	102.7	3.6	96.6
71801/80802		0.5	0.0	0.5	0.0
	71801	210.6	189.6	21	90.0
71802/80109		97.9	95.6	2.3	97.7
71802/80802		0.3	0.0	0.3	0.0
71802/81806		91.4	78.1	13.3	85.4
71802/81834		246.6	243.4	3.2	98.7
71802/81835		112.3	110.7	1.6	98.6

71802/81801	8.8	5.2	3.6	59.1
71802	557.3	533.0	24.3	95.6
70105/80101	57.7	56.9	0.8	98.6
70105/80802	0.2	0.2	0	100.0
70105/82201	6.0	6.0	0	100.0
70105/80825	11.9	11.5	0.4	96.6
70105	75.8	74.6	1.2	98.4
70106/80101	354.5	351.1	3.4	99.0
70106/80106	67.2	67	0.2	99.7
70106/80802	27.8	27.8	0	100.0
70106/81102	40.0	40.0	0	100.0
70106/82212	2.5	2.5	0	100.0
70106/83112	0.2	0.0	0.2	0.0
70106	492.2	488.4	3.8	99.2
71702/80101	76.7	71.4	5.3	93.1
71702/80802	0	0	0	#DIV/0!
71702/80214	1.5	1.5	0	100.0
71702	78.2	72.9	5.3	93.2
71602/80101	349.8	314.7	35.1	90.0
71602/80109	15.9	15.5	0.4	97.5
71602/80302	74.1	74.1	0	100.0
71602/80802	1.0	1.0	0.0	100.0
71602	440.8	405.3	35.5	91.9
70503/80513	338.2	119.7	218.5	35.4
70106/81405	120.0	16.8	103.2	14.0
70106/81405 ЖДҮДС	0.0	0.0	0	#DIV/0!
70106/81701	40.0	25.3	14.7	63.3
	2353.1	1925.6	427.5	81.8

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1925.8 төгрөг буюу 81.8 хувьтай байгаа нь засгийн газрын хэмнэлтийн бодлоготой холбоотой шалтгаалсан байна. Үүнд: цалин шимтгэл 51.0 сая, хүүхдийн хоол 24.0 сая, урсгал засвар, багаж техник худалдан авах зардал 0.2 сая, бараа үйлчилгээний бусад зардал 15.0 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Хөрөнгө оруулалтын 14 төсөл, арга хэмжээнд 119.5 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 80.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 142.6 сая, ЗДНХ-өөс 13.5 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 129.8 сая нийт 286.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Хүснэгт №	Нэмэлт санхүүжилтийн орлого байгууллагаар							/сая.төг/		
Үзүүлэлт	ЗДТГ	ИТХ	ЕБС	СӨБ	ЭМТ	Соёл	ОНХС	БХС	ЖДҮ	
Нийт орлого										
	286.1	12.5	2.0	0.3	1.6	269.4	0.0		0.0	
Нийт зарлага										
	280.1	12.4	2.0	0.23	1.4	264.1	0.0		0.0	

Төсөвт төвлөрүүлсэн									
	0.32	0.07	0.0	0.07	0.18	0.0	0.0	0.0	0.0
үлдэгдэл	5.3								5.3

Үүнээс цалин шимтгэлд 38.4, хангамж бараа материалын зардалд 12.3, эм хоол хүнс нормын хувцасанд 122.9, урсгал засвар багаж техник хэрэгсэлд 2.0, бараа үйлчилгээний бусад зардалд 14.4, хөрөнгийн зардалд 40.4 сая, дотоод томилолтын зардалд 1.1, тэтгэмж урамшуулалд 48.6 нийт 280.1 сая төгрөгийг зарцуулж, 0.32 сая төгрөгийн төсөвт төвлөрүүлж үлдэгдэл 5.3 сая төгрөг эрүүл мэндийн төвийн төрийн сангийн харилцах дансанд үлдсэн байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 151 мэдээллээс 145 мэдээллийг хугацаанд нь, 6 мэдээллийг хугацаа хоцроож, таван сая төгрөгөөс дээш 8 удаагийн мэдээллийг байршуулаагүй байна.

3.7.1 Бусад хууль тогтоомжийн хүрээнд:

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийлээ.

Аудитын илрүүлэлт:

- Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй. /ЕБС 9.1 сая төгрөг, ЗДТГ 3,6 сая төгрөг/
- Шилэн дансны тухай хуулийн 6.2.4, 6.3.6, 6.4.2, 6.4.4, 6.4.5, 6.4.7, 6.5.4 дахь заалттыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна. /ОНХС таван сая төгрөгөөс дээш 8 удаагийн 78.5 сая төгрөгийн худалдан авалт, ЕБС ,ЭМТ таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 31 удаагийн 666.8 сая төгрөгийн орлого, 13 удаагийн 220.5 сая төгрөгийн зарлага, 6 удаагийн 59.5 сая төгрөгийн худалдан авалт/

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 151.5 сая төгрөгийн 4 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт №12 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт							
Албан шаардлага	1				1		

Зөвлөмж	4	151.9	1	10.0	3	141.9	0
Нийт	5	151.9	1	141.9	4	141.9	

3.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн эсэхийг нягтлах, биелэлтийг тооцох.

4 Аудитын илрүүлэлт, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 2 байгууллагад дүгнэлт гаргаж, 4 байгууллага, 4 тусгай сан түүврээр хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”-1, “Хязгаарлалттай” -1 /Эрүүл мэндийн төв/ дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 152.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 271.9 сая төгрөгийн 9 алдааг аудитын явцад залруулж, 1.9 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 139.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 7 албан шаардлага хүргүүлж, 10.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 7 зөвлөмжийг хүргүүллээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн алдаа байхгүй байна.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт

- 2021 оны малын хөлийн татвар 28.8, газрын төлбөр 5.4 сая төгрөгийг тус тус дутуу төвлөрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 41.2.1-д "хуулийн дагуу улс орон нутгийн төсөвт оруулах болон тухайн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасныг зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд төлбөрийн акт хүргүүллээ.
- Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөс өвс худалдан авсан 5500.0 мянган төгрөгөөс ХХОАТ суутган шилжүүлээгүй нь санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийн хангаагүй зөрчилд төлбөрийн акт хүргүүллээ.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн албан шаардлага

- Таван сая төгрөгөөс дээш 8 удаагийн 78.5 сая төгрөгийн худалдан авалтын мэдээллийг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6.4.4, 6.4.5 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй зөрчилд албан шаардлага хүргүүллээ.
- ЗДТГ бүтэц орон тоо, батлагдсан төсөвт суугаагүй хамтран ажиллах гэрээ байгуулсан 5 ус түгээгчийн хувь хүнээс төлөх НДШ-2.6, ажил олгогчоос төлөх НДШ -д 2,856.0, нийт 5483.5 мянгаг төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 16.5.3 дахь заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын зохистой бөгөөд нийцсэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлангийн үзэл баримтлал

1.1. Илрүүлэлт:

Төсвийн тухай хуулийн 54.4.5 дахь заалтын дагуу тайлангийн иж бүрдлийг хангаж ирүүлээгүй нь санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллах.

2. Байгаль хамгаалах сан:

2.1. Илрүүлэлт:

Байгаль хамгаалах сангаас сэлбэг хэрэгслийн зардалд 1.4, нохой усгалын зардалд 0.5 сая төгрөгийг олгож зориулалт бус зарцуулсан нь 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 3 дахь заалттай бүрэн нийцээгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж

Байгаль хамгаалах сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, холбогдох хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлэн ажиллах.

3. Дотоод хяналт:

3.1. Илрүүлэлт:

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтыг зохион байгуулах журмын дагуу байгууллагын дотоод хяналтын журамыг байгууллагынхаа онцлогт тохируулан боловсруулж дотоод хяналтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй.

3.2. Өгсөн зөвлөмж

Байгууллагын додоот хяналт шалгалтын журмыг холбогдох журмын дагуу боловсруулан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2022 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Хавсралт

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая.төгрөг/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Орхон сумын Засаг дарга	7	120.7			2	39.4	2	84.0	2	0.0